

БАТЛАВ  
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ  
ДАРГА 1877 Ц.ТӨМӨРБААТАР

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРДЭНЭЦОГТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 08 сарын 05

Эрдэнэцогт

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1 Орлоготой иргэн**

- 1.1.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж бага хүүтэй зээл сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгоно.
- 1.1.2 Өрхийн сёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх. Орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.3 Иргэдийн туршлага ур чадварт түшиглэн хувиар хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжин, шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгоно.

**1.2 Эрүүл иргэн**

- 1.2.1 Эрүүл мэндийн оношилгооны чадамжийг дээшлүүлж эмч, мэргэжилтнийг нарийн мэргэжлээр бэлтгэн, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.2 "Элэг бүтэн Баянхонгор" хөтөлбөрийг үргэлжлүүлж, "Хавдрын эсрэг хамтдаа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- 1.2.3 Идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэх дасгал, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зам, халдварт бус өвчлөлийг бууруулан, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.


**1.3 Чанартай боловсрол**

- 1.3.1 Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгт сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, тогтвортой суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.2 Орон нутаг дахь их дээд сургууль, коллеж, Мэргэжил Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн үйл ажиллагааг сайжруулах, суралцагчдын тоог нэмэгдүүлэн ажиллана.
- 1.3.3 Хувь хүн, гэр бүл, байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлого боловсруулна.
- 1.3.4 Сурагчдын сурлагын амжилт, чанар стандарт хангалтыг сайжруулах бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлнэ.

**1.4 Тогтвортой-Амар амгалан гэр бүл**

- 1.4.1 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

000000001



- 1.4.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамж үйлчилгээг төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.3 Хөдөлмөр эрхлэх зуучлалын үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.

### **1.5. Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр**

- 1.5.1 Хүүхдийн хүчирхийлэл, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна.
- 1.5.2 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж хяналтыг сайжруулах

### **1.6. Залуучуудыг дэмжих чиглэлээр**

- 1.6.1 Залуу гэр бүлийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлагыг дээшлүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

### **1.7. Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг дэмжих**

- 1.7.1 Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, тэгш хамран сургах, нөхөн сэргээх өдрийн үйлчилгээг дэмжин ажиллана.

### **1.8. Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ**

- 1.8.1 Ахмад настны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөгжих төв, цэцэрлэгт хүрээлэнг байгуулах, сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

### **1.9. Үндэсний бахархал, өв соёл, спорт**

- 1.9.1 Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

- 2.1 Сүүний үйлдвэрийг тогтмол үйл ажиллагаатай болгож, үйлдвэрийг хэвийн ажиллагаатай болгоход удирдлага зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

### **2.1. Төрөлжсөн аялал жуулчлал**

- 2.1.1 Сумын нутагт байрлах түүхийн үнэт өв Шатар чулууг гүйцээн тохижуулж, Сарлагийн баяр, Пандэчойнхорлын хийдийг түшиглэн буян хураах аялал жуулчлалыг хөгжүүлэх.

### **2.2. Дэд бүтэц**

- 2.2.1 Ямаат 2 дугаар багт багийн төвийг шинээр, G mobile станц барьж, сүлжээ ашиглалтад оруулна.
- 2.2.2 Өвгөнжаргалант 3 дугаар баг дээр бага сургууль, цэцэрлэгийн барилга барьж, ашиглалтад оруулна.

### **2.3. Авто зам**

- 2.3.1 Босоо тэнхлэгийн 700 км авто замыг барьж эхлүүлснээр Баянхонгор, 1417143544 Эрдэнэцогт сумыг хатуу хүчилттай авто замаар холбогдоно.

000000002

2.3.2 Сумын төвд 2 км хатуу хүчилттэй авто зам тавина.

### ГУРАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



- 3.1 Эрхэтхайрхан уулыг улсын тахилгатай уул болгоно.
- 3.2 Дэвөнтийн уурхайн удирдлагуудтай тохиролцож, хямд үнэтэй нүүрсээр төрийн албан хаагчдыг дэмжинэ.
- 3.3 Хогийн цэгийг Ландфилийн аргаар булшилж, шинэ хогийн машинтай болно
- 3.4 Баянхонгор аймгийн 8-р баг, Шаргалжуутын газар нутаг Эрдэнэцогт сумын нутаг болохыг баталгаажуулна.
- 3.5 Шаргалжуутын Лхамын рашааныг савлаж, Витафит компанийн хөрөнгө оруулалттаар тоног төхөөрөмж авна.
- 3.6 Байнгын ажлын байр 20, түр ажлын байр жил бүр 80-с буулгахгүй.
- 3.7 Хүрэм, Боржин чулуу түшиглэж барилгын материалын үйлдвэр байгуулна.
- 3.8 Жишиг сум төслийг 100 хувь хэрэгжүүлнэ.


### ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1 Шинээр баригдах Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Засаг даргын тамгын газрын урдуур нийт 2 га газарт олон төрлийн мод тариалж, ногоон байгууламж бий болгоно.
- 4.2 Дотооддоо төмс хүнсний ногоогоор хангах, ногоочдыг дэмжих, Техник тоног төхөөрөмж, ногоо хадгалах зоорь, мах хадгалах хүйтэн зоорь барьснаар хүнсний ногоо, махны нөөцийг нэмэгдүүлнэ.
- 4.3 Баянхонгор аймагт Эрдэнэцогт нэртэй сүү цагаан идээний зах байгуулна.

### ТАВ.ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1 Уур амьсгалд дасан зохицох хөдөө аж ахуй, мал аж ахуйн төслийн хүрээнд сумын хэмжээнд 100-н өвөлжөө, хаваржaa засварлах буюу шинээр барьснаар мал аж ахуйн материаллаг баазыг өргөтгөх. Хүн ам, малын ус дутагдалтай байгаа зарим газруудад төслийн хүрээнд шинээр 12 худаг гаргана. Шинээр сумын төвд хүн амын ундны усанд зориулан ухаалаг худаг 2-г гаргана.

МЭДЭЭЛЛИЙГ БИЧСЭН  
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫГ ТӨЛӨӨЛЖ  
ДЭД ДАРГА  Б.ЭНХБААТАР

  
  
23  
000005003